

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	9
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал	10
3.1	Бараа материалын данстай холбоотой асуудал.....	10
3.2	Орлогын данстай холбоотой асуудал.....	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТЛЕЙХАН
ТАНАА

2020.03.13 № 06/788
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрчим хүчний зохицуулах хороо нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хорооны дарга А.Тлейхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн шатахууныг нормын дагуу зарцуулах, төлбөрийн цахим баримтыг бүрэн бүрдүүлэх, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Мишээл-Од Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2019 оны санхүүгийн тайланг “Мишээл-Од Аудит” ХХК-д 2020 оны 01 дугаар сарын 29-ний өдрийн 8/107 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэн, Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэл-1 Эрчим хүчний тухай хуулиар:

- Тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Тариф тогтоох аргачлал боловсруулах, хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;
- Эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхыг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ тарифын тогтолцоог бий болгох;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх;
- Хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах;

Үйл ажиллагааны чиглэл-2 Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар:

- Дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгчийн үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний тооцоог хянаж, хуулийн хүрээнд тарифыг батлах;
- Дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгчийн дамжуулагчтай байгуулах гэрээний загварыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

Үйл ажиллагааны чиглэл-3 Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиар:

- Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, үндэсний хөтөлбөр боловсруулах;
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчээс эрчим хүчний хэрэглээ, хэмнэлтийн талаар тайлан гаргуулж, хянах;
- Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох;
- Эрчим хүчний аудитор, эрчим хүчний хэмнэлтийн менежерийн эрх олгох, бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”

- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашини шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашини эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашини сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эрчим хүчний зохицуулах хороо нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрчим хүчний зохицуулах хорооны бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогоор сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,255.0 сая төгрөгөөс тооцон 65.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 5,615.0 сая төгрөгөөс тооцон 112.3 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,226.8 сая төгрөгөөр буюу 27.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан ашиг, эздийн өмчийн бусад хэсэг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	563.0	947.5	384.5
Авлага	606.1	433.3	-172.8
Урьдчилгаа	190.6	6.9	-183.7
Бараа материал	10.8	16.7	5.9
Үндсэн хөрөнгө	3,136.8	4,318.8	1182
Нийт хөрөнгө	4,507.3	5,723.2	1215.9
Өр төлбөр	277.1	286.4	9.3
Эздийн өмч	104.5	104.5	0
Эздийн өмчийн бусад хэсэг	101.7	35.6	-66.1
Хуримтлагдсан ашиг	3,962.1	5,234.8	1,272.7
Дахин үнэлгээний нэмэгдэл	61.9	61.9	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,507.3	5,723.2	1215.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 384.5 сая төгрөгөөр өссөн нь орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн болон зардлын хэмнэлт үүссэнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 172.8 сая төгрөгөөр буурсан нь улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр 159.2 сая төгрөгөөр, зохицуулалтын үйлчилгээний хөлсний авлага 29.0 сая төгрөгөөр, хүмүүсээс авах авлага 1.5 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2017-2018 онуудад үүссэн 138.6 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Үүний 29.6 сая төгрөгийн авах авлагыг Зэт ти эм эн жи ХХК-г эрэн сурвалжлуулахаар Хан уул дүүргийн цагдаагийн газарт хандсан, Шинэ азиа майнинг групп ХХК, Энержи плас ХХК, Хөдөөгийн цахилгаан ХХК-ийн 109.0 сая төгрөгийн авлагыг 2019-2020 онуудад барагдуулахаар эвлэрлийн гэрээ байгуулсан байна. Үлдсэн 305.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл нь зохицуулалтын үйлчилгээний урсгал авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.9 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын үлдэгдлийн өсөлтөөс шалтгаалжээ. Оны эцэст харилцагч олон улсын байгууллагын төлөөлөгч, харилцагч нарт болон хурал, зөвлөгөөнд ашиглах зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооны таних тэмдэг бүхий тэмдэглэлийн дэвтэр, үзгийг шууд худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,182.0 сая төгрөгөөр өссөн нь оффисын зориулалттай барилга шинээр барьж, өргөтгөл барилгын фасад засварын ажил явагдаж 1,182.0 сая төгрөгийн зардлыг дуусаагүй барилга болон барилгын өртөгт капиталжуулж бүртгэснээс шалтгаалжээ. Мөн ТӨБЗГ-ын 2019 оны А-5/1358 болон А-1/3595 тоот албан бичиг, 195 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 96.5 сая төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 9.3 сая төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг 20.4 сая төгрөг, урьдчилж орсон орлого 9.0 сая төгрөгөөр нэмэгдэж, татварын өр 20.0 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга нь эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэлтэй 2005 оноос тус хорооны ажилтнуудад орон сууцны хөнгөлөлт олгохоор сан үүсгэж, орон сууцыг үндсэн хөрөнгөнд орлогод авч, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцож, хасалт хийх үед үлдэгдэл өртгийн зөрүү үүссэн 66.1 сая төгрөгийг аудитын зөвлөмжийн дагуу хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

2.9. Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 15 тоот тогтоолоор Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 4,447.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 1,876.7 сая төгрөгөөр тус тус баталж 1,310.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Эрчим хүчний зохицуулах хороо нь тайлант онд 5,615.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 4,408.6 сая төгрөгийг зарцуулж, 1,206.6 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Өмнөх оноос орлого 315.3 сая төгрөгөөр өсөж, зардал 50.4 сая төгрөгөөр буурч ашиг өмнөх оноос 365.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2019 онд төлөвлөгөөнд тусгаагүй тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулалтын хөлс 507.1 сая төгрөг, бусад орлого 263.1 сая төгрөг орсон мөн зардлыг 581.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласнаас шалтгаалжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 111.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, залруулагдаагүй 1 алдаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 100.0 сая төгрөгийн 3 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

- Тайлант онд 26.9 сая төгрөгийн сургалтын төлбөр, 10.5 сая төгрөгийн гишүүний хураамж нийт 37.4 сая төгрөгийн монгол улсаас эх үүсвэртэй орлогыг гадаадын аж ахуйн нэгжид шилжүүлэхдээ 7.5 сая төгрөгийн ААНОАТ, 3.7 сая төгрөгийн НӨАТ нийт 11.2 сая төгрөгийн татварыг суутган аваагүй, татварын тайланд дутуу тусгасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д “оршин суугч бус этгээдээс энэ хуулийн 7.2.5-д заасан гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнийн дүнгээс албан татварыг суутган авч төсөвт төлнө”, ААНОАТ-ын 17 дугаар зүйлийн 17.2-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна: 17.2.9.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон дараах орлогод 20 хувиар” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад татварын тайланг залруулж, тусгасан.

- Тайлант онд орлогын төлөвлөгөө 507.1 сая төгрөгөөр давсан, 581.2 сая төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн зэргээс 1,206.6 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байгаа нь зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндрөөр тогтоосон, орлого, үйл ажиллагааны зардлыг үндэслэлгүй тогтоодогтой холбоотой байна. Энэ нь эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д “Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжнэ”, 9 дүгээр зүйлийн 9.1.18-д “эрчим хүчний зохицуулалттай үйлчилгээний хөлс тооцох аргачлал, уг үйлчилгээний хөлсний хэмжээг батлах, Эрчим хүчний зохицуулах хорооны 494 дүгээр тогтоолын 3-д Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний нийт хөлсний хэмжээ нь Хорооны тухайн

жилийн батлагдсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хангахуйц байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 100.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус хороо нь 2018 онд 840.9 сая төгрөг, 2019 онд 1,206.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байгаа нь эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хуулиар олгогдсон эрх, үүргээ давуу байдлаар ашиглан өндөр тооцож авч байгаатай холбоотой гэж үзэн албан шаардлага хүргүүлж, үйлчилгээний хөлсийг хэр үндэслэлтэй тогтоож байгаа талаар дараагийн аудитаар авч үзнэ.

Мөн 2018 он 10 сараас конторын зориулалттай барилга барьж 2019 оны 12 сард дотор засал дуусаж, 2020 оны 02 сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд барилга хүлээн авсан акт үйлдэгдэж дуусах шатандаа байгаа тул 2,820.5 сая төгрөгийн дуусаагүй үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн эсэхийг дараагийн аудитаар хянана.

Өмнөх онуудад үүссэн 6 харилцагчтай холбоотой 150.7 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэгдсэнийг мөн дараагийн аудитаар хянах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрчим хүчний зохицуулах хороо нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 116.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 61.5 сая төгрөгийн албан шаардлагыг барагдуулж биелэлт 53.0 хувьтай бөгөөд Шинэ Азиа майнинг групп ХХК-ийн 54.5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Нийт 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 100.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 112.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хуанлийн хоногоор тооцож олгосон, нэг өдрийн явах километрийн дээд хязгаарыг хэтрүүлснээс 1.8 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын 2-т “Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см³-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай” гэсэн тогтоолтой нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчих;

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын дагуу шатахууны тооцоог үнэн зөв тооцох

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 4 харилцагчтай холбоотой 8.3 сая төгрөгийн төлбөрийн цахим баримт байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагаас төлбөрийн баримтыг гаргуулан авах, хяналт тавьж ажиллах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийн дагуу баримтыг бүрдүүлж, хяналтыг сайжруулан ажиллана.

3.3 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт хийхдээ 2 төрлийн 89.9 сая төгрөгийн худалдан авалтыг цахим системд мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-д “Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ” 33.2.1-д “үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт хийхдээ цахим системд зарлаж, үр дүнг тухай бүр мэдээлэх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллуулах талаар асуудлын бүртгэлд дэлгэрэнгүй тайлбар гаргасан;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн Санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	562,986,618.19	947,510,264.86
1.1.2	Дансны авлага	425,593,458.20	397,411,312.29
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	175,924,266.69	33,521,940.84
1.1.4	Бусад авлага	4,599,591.08	2,267,965.45
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	10,787,885.40	16,733,153.93
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	190,614,385.00	6,931,210.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,370,506,204.56	1,404,375,847.37
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,607,896,282.98	4,274,649,221.95
1.2.2	Биет бус хөрөнгө	40,667,000.00	39,479,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,074,026.97	4,676,832.17
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,486,148,328.00	
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,136,785,637.95	4,318,805,054.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,507,291,842.51	5,723,180,901.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,263,514.00	22,620,265.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	20,042,605.28	
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	254,765,133.90	263,732,987.86
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		

2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	277,071,253.18	286,353,252.86
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	277,071,253.18	286,353,252.86
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	104,537,450.95	104,537,450.95
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	61,916,617.76	61,916,617.76
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	101,693,249.21	35,618,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,962,073,271.41	5,234,755,579.92
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,230,220,589.33	5,436,827,648.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,507,291,842.51	5,723,180,901.49

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,139,993,720.90	5,352,129,291.17
2	Борлуулалтын өртөг	3,620,642,262.57	3,658,459,056.19
3	Нийт ашиг(алдагдал)	1,519,351,458.33	1,693,670,234.98
4	Түрээсийн орлого		-
5	Хүүгийн орлого	51,202,543.08	13,306,830.32
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	108,729,679.80	249,764,491.26
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	340,441,708.55	384,286,856.53
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	105,247,111.00	219,968,660.99
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(212,643.89)	(245,864.64)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(251,548,501.50)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	981,833,716.27	1,352,240,174.40
19	Орлогын татварын зардал	140,881,995.70	145,633,115.10
20	Татварын дараах ашиг (алдагдал)	840,951,720.57	1,206,607,059.30
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	840,951,720.57	1,206,607,059.30
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	840,951,720.57	1,206,607,059.30
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95	364,857,785.30	66,075,249.21	2,756,263,765.54	3,291,734,251.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95	364,857,785.30	66,075,249.21	2,756,263,765.54	3,291,734,251.00
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				840,951,720.57	840,951,720.57
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт	-		35,618,000.00		35,618,000.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(302,941,167.54)		364,857,785.30	61,916,617.76
2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	101,693,249.21	3,962,073,271.41	4,230,220,589.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(66,075,249.21)	66,075,249.21	-
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	4,028,148,520.62	4,230,220,589.33
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-	1,206,607,059.30	1,206,607,059.30
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			-		-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-		-
2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	104,537,450.95	61,916,617.76	35,618,000.00	5,234,755,579.92	5,436,827,648.63

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,042,982,032.36	6,602,002,326.54
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,455,882,774.64	5,916,502,216.11
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	155,249,074.76	286,557,950.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	20,050,417.00	11,043,759.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	
1.1.6	Бусад мөнгөн орлого	411,799,765.96	387,898,401.43
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,570,421,841.08	4,943,580,418.55
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,587,525,907.06	2,497,392,146.99
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	566,668,970.21	637,016,597.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	432,047,253.60	251,389,165.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	55,679,820.45	96,223,970.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	90,002,647.30	90,197,944.60
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	714,034,124.30	1,239,631,013.97
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	6,695,096.53	7,274,000.29
1.2.9	Бусад мөнгөн зарлага	117,768,021.63	124,455,579.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	472,560,191.28	1,658,421,907.99
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,202,543.08	13,306,830.32
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	51,202,543.08	13,306,830.32
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,643,862,255.00	1,287,395,227.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,641,882,255.00	1,287,395,227.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,980,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,592,659,711.92)	(1,274,088,396.68)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5			-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	294,640.11	190,135.36
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,119,804,880.53)	384,523,646.67
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,682,791,498.72	562,986,618.19
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	562,986,618.19	947,510,264.86

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.10	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:		
				САГ-2020/62/СТА-ТӨҮГ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлангийн аудит			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд орлогын төлөвлөгөө 507.1 сая төгрөгөөр давсан, 581.2 сая төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн зэргээс 1,206.6 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байгаа нь зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндрөөр тогтоосон, орлого, үйл ажиллагааны зардлыг үндэслэлгүй тогтоодогтой холбоотой байна.		Албан шаардлага өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
2	Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хуанлийн хоногоор тооцож олгосон, нэг өдрийн явах километрийн дээд хязгаарыг хэтрүүлснээс 1.8 сая төгрөгийн шатахуун илүү олгосон	1.8	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
3	Мөнгөн хөрөнгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 4 харилцагчтай холбоотой 8.3 сая төгрөгийн төлбөрийн баримтыг хүлээн аваагүй байна.	8.3	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
4	Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт хийхдээ 2 төрлийн 89.9 сая төгрөгийн худалдан авалтыг цахим системд мэдээллийг байршуулаагүй байна.	89.9	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Тлейхан М.Мандах
	Нийт дүн	100.0			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/118

Улаанбаатар хот

САГ-2020/62/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд орлогын төлөвлөгөө 507.1 сая төгрөгөөр давсан, 581.2 сая төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн зэргээс 1,217.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байгаа нь зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өндрөөр тогтоосон, орлого, үйл ажиллагааны зардлыг үндэслэлгүй тогтоодогтой холбоотой байна. Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д “Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжнэ”, 9 дүгээр зүйлийн 9.1.18-д “эрчим хүчний зохицуулалттай үйлчилгээний хөлс тооцох аргачлал, уг үйлчилгээний хөлсний хэмжээг батлах, Эрчим хүчний зохицуулах хорооны 494 дүгээр тогтоолын 3-д Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний нийт хөлсний хэмжээ нь Хорооны тухайн жилийн батлагдсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хангахуйц байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-т “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д “Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжнэ”, Эрчим хүчний зохицуулах хорооны 494 дүгээр тогтоолын 3-д “Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний нийт хөлсний хэмжээ нь Хорооны тухайн жилийн батлагдсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хангахуйц байна” гэсэн заалтуудад нийцүүлэн эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2020 оноос үндэслэлтэй төлөвлөж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хэт өндөр үйлчилгээний хөлс авахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан, нягтлан бодогч М.Мандах нарт хариуцуулав.

ӨГСӨН:
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]* Л.МӨНХЦАЦРАЛ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *[Signature]* Т.ОДОНЧИМЭГ

АЛБАН ШААРДАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА *[Signature]* А.ТЛЕЙХАН
НЯГТЛАН БОДОГЧ *[Signature]* М.МАНДАХ

Акт, албан шаардлагын биелэлтийг харгалдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тусгай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.